



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 1/104

Бөхт

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Босго үнэ тогтоох тухай” 124 дүгээр тогтоол, сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 109 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны мал тооо толгойн албан татварын хөрөнгө оруулалтаар хийгдэх Малчдын зөвлөгөөнд зарцуулагдах 150 ширхэг дэвтэр, балны үнэ 3,000,000 (гурван сая) төгрөгийг Бага баян хайрхан ХХК-аас худалдан авах, Хоршоологчдын холбооны зөвлөх Н.Баасанхүүд сургалтын зардал 350,000 (гурван зуун тавин мянган) төгрөг, Орон нутгийн түүх судлаач Монголын үндэсний морин уралдаан, уяачдын холбооны ажлын албаны ажилтан Н.Сэрээтэрт сургалтын зардалд 580,000 (таван зуун наян мянган) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Малчдад зохион байгуулах сургалтыг чанартай зохион байгуулахыг Хоршоологчдын холбооны зөвлөх (Н.Баасанхүү), Орон нутгийн түүх судлаач (Н.Сэрээтэр) нарт малчдад чанартай дэвтэр бал нийлүүлэхийг Бага баян хайрхан ХХК-д тус тус даалгасугай.

3. Дээрх ажлын гэрээг байгуулан дүгнэж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д, ажлын уялдааг хангаж, гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Х.Уугандорж) нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/65 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ